

**“БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД
НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ”
ТӨСӨЛ”-ИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103 /

Агуулга

1	ТАНИЛЦУУЛГА	5
1.1	Ерөнхий мэдээлэл	5
1.2	Баянхошуу нийгмийн барилга байгууламжийн ажлын явц, байршил.....	6
1.3	Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн танилцуулга.....	5
1.3.1	ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	5
1.3.2	DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл.....	7
1.3.3	SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл	9
1.3.4	DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл	11
1.3.5	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл.....	12
1.3.6	HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл	14
1.3.7	FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл	15
1.3.8	BKHS гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл	17
2	Байгаль орчны төлөв байдлын судалгаа	19
2.1	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	19
2.2	Уур амьсгал.....	20
2.3	Агаарын чанар	20
2.3.1	Агаарын чанарын ерөнхий төлөв.....	20
2.4	Геологийн тогтоц	20
2.4.1	Геоморфологийн нөхцөл	21
2.5	Гадаргын ус.....	21
2.5.1	Төслийн талбай орчмын гадаргын усны сүлжээ	22
2.6	Гидрогеологийн нөхцөл	22
2.7	Хөрсөн бүрхэвч	23
2.7.1	Газрын доройтол, хөрсний элэгдэл эвдрэл	23
2.8	Ургамлан нөмрөг.....	24
2.9	Амьтны аймаг.....	24
2.9.1	Төслийн талбай орчмын амьтны зүйл бүрдэл	24
2.10	Тусгай хамгаалалттай газар нутаг	24

2.11	Түүх, соёлын өв	25
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц бүрэлдэхүүн, нийт зардал.....	25
4	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	27
5	НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	67
5.1.1	Нөхөн сэргээлтийн нэгдсэн дүн	68
5.1.2	ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг	68
5.1.3	DDCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл.....	69
5.1.4	DDPK-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл	70
5.1.5	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл.....	71
5.1.6	FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл	72
5.1.7	BKHS гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл	73
5.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	75
6	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө:	75
7	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	76
8	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:.....	77
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	82
10	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).....	84
11	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	91
12	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА хэмжээ	92

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн барьж байгуулах объектууд	8
Хүснэгт 3-1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	26
Хүснэгт 4-1. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Хүүхдийн цэцэрлэг барих ASKG-BKH багц	27
Хүснэгт 4-2. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Олон нийтийн хөгжлийн төв барих DDCCD-BKH багц	33

Хүснэгт 4-3. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Гал унтраах ангийн барилга барих FS-BKH багц.....	38
Хүснэгт 4-4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн байгуулах DDPK-BKH багц.....	45
Хүснэгт 4-5. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: DDCD-BKH гэрээний дугаартай Баянхошуу дэд төвийн олон нийтийн хөгжлийн төв барих төсөл	49
Хүснэгт 4-6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ: Салбар шугамын холболт хийх HSSC-C багц	52
Хүснэгт 7. BKHS гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл.....	60
Хүснэгт 5-1. Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	67
Хүснэгт 5-2. Нөхөн сэргээлтийн нэгдсэн дүн.....	68
Хүснэгт 7-1. Барилга баригдах газрын эзэмшлийн нөхцөл байдал	76
Хүснэгт 8-1. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	77
Хүснэгт 9-1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	82
Хүснэгт 10-1. Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр	84
Хүснэгт 11-1. <i>БОМТ хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.</i>	91
Хүснэгт 12-1. Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад мэдээлэл өгөх, тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээ.....	92

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төсөл хэрэгжих талбайн байршил	7
Зураг 1-2. Барилгын ажлын явц	5
Зураг 2-1. Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих талбайн физик газарзүйн байрлал	19
Зураг 2-2. Төслийн талбай, түүний орчмын геологийн зураг	21
Зураг 2-3. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ.....	22
Зураг 2-4. Төслийн талбай, түүний орчмын гидрогеологи.....	23
Зураг 2-5. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд.....	25

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Ерөнхий мэдээлэл

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл юм.

Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь Улаанбаатар хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь:

- (i) Эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох
- (ii) Ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох;
- (iii) Зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн 2-р үе шатанд Баянхошуу-Ханын материалд хүүхдийн цэцэрлэг, спорт цогцолбор, эмзэг давхаргын өрхүүдэд зориулсан түрээсийн орон сууц, иргэний хөгжлийн төв, бичил цэцэрлэгт хүрээлэн зэрэг нийгэм, олон нийтэд үйлчлэх барилга, байгууламжийг барих ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

2023 оны 11 дугаар сарын байдлаар Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төсөлд хамаарагдах нийт 8 төслийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалт явагдахаас. Ковид болон барааны үнийн өсөлтөөс шалтгаалж 3 төслийн барилга байгууламжын ажил 2021 оны 8-р сараас эхэлж зогссон байгаа бол 3 төслийн барилга байгууламжийн ажил хэвийн явагдаж байгаа ба 2 төсөл тендерийн шалгаруулалтын явцадтай байна.

Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2020 онд хийгдэж, БОАЖЯ-аар батлагдсан. энэхүү төрийн захиргааны байгууллагаас батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянхошуу нийгмийн барилга байгууламжын ерөнхий БОМТ 2021 оны биелэлт, хэрэгжилтийн тайланг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам (БОНХЯ)-ны сайдын баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” А-618 дагуу боловсруулав.


1.2 Баянхошуу нийгмийн барилга байгууламжийн ажлын явц, байршил

Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн хүрээнд шинээр баригдах дараах барилга байгууламжууд, тэдгээрийн хэрэгжих орчныг дараах газрыг хамрах болно. Үүнд:

1. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах 240 хүүхдийн цэцэрлэг
2. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах "Олон нийтийн хөгжлийн төв"
3. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Спорт цогцолбор
4. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Гал унтраах, аврах 29-р ангийн барилга
5. Сонгинохайрхан дүүргийн 6-р хороонд баригдах Зорилтот бүлгийн орон сууц
6. Сонгинохайрхан дүүргийн 24, 25-р хороонд баригдах Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн
7. Сонгинохайрхан дүүргийн 24 хороонд баригдах Баянхошуу талбай
8. Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд баригдах Спорт цогцолбор, Олон нийтийн хөгжлийн төв, 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгуудыг цэвэр бохир усны төвлөрсөн шугамд холбох, Баянхошуу дэд төвд дулааны салбар шугамын холболт угсралтын ажлууд хийх

“Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төслийн хүрээнд барьж байгуулах объектуудын мэдээллийг доорх хүснэгтэд хураангуйлан үзүүлэв.


Зураг 1-1. “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих” төсөл хэрэгжих талбайн байршил



Хүснэгт 1-1. Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн барьж байгуулах объектууд

№	Гэрээний дугаар	Шинээр баригдах нийгмийн байгууламжууд	Хүчин чадал, хэмжээ	2023 онд барилгын ажил явагдах хугацаа			2023 оны барилгын ажлын явц	Гүйцэтгэгч
				Эхлэх	Дуусах	Үргэлжлэх		
1	ASKG-BKH	Хүүхдийн цэцэрлэг	240 ортой, 2 давхар барилга	2021.04.01	2023.10.31	17 сар	16% Барилгын ажил зогссон	“Цаст констракшн” ХХК
2	DDCD-BKH	Олон нийтийн хөгжлийн төв	Сургалт хурлын заалт 2 давхар барилга	2021.04.01	2023.10.31	17 сар	15% Барилгын ажил зогссон	“Тэш-Агь констракшн” ХХК
3	BDSC-BKH	Спорт цогцолбор	610 хүний суудалтай спорт заал, усан бассейн, бөх, бокс, фитнес танхимуудтай	2023.04.01	2023.10.31	15 сар	25%	Стандарт Холдинг ХХК-
4	FSBKH	Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга	Оффис, граж, агуулах зэрэг 3 барилга байгууламж шинээр барина.	2021.06.01	2023.10.31	15 сар		-
5	DDPK-BKH	Баянхошуу цэцэрлэгт хүрээлэн	Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай	2021.04.01	2023.10.31	17 сар	60% Барилгын ажил зогссон	“Дүүрэн Трейд” ХХК
6	SHS	Зорилтот бүлгийн орон сууц	9 давхар 2 барилга, тус бүр 63 айл	2021.04.01	2023.10.31	17 сар	90%	“Монкон констракшн” ХХК
7	HSSC-C	Салбар шугамын холболтын ажлууд	Баянхошуу дэд төвд буй нийгмийн барилгуудыг цэвэр, бохир ус, дулаан, цахилгааны төвлөрсөн шугамд холбох ажлууд	2023.04.01	2023.10.31	15 сар	40%	“Эс энд эй трейд” ХХК -
8	/BKHS/	Баянхошуу талбай	4,2 га талбайд амаралтын талбай байгуулна.	2023.04.01	2023.10.31	15 сар	Барилгын ажил эхлээгүй	-
	Барилгын ажил зогссон	Барилгын ажил хэвийн явагдаж байгаа	Барилгын ажил эхлээгүй					

Зураг 1-2. Барилгын ажлын явц



1.3 Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих төслийн танилцуулга

1.3.1 ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэг

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	ASKG гэрээний дугаартай 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Цаст констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011044119, регистрийн дугаар 2791668.
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2023 он /2 жил/ Барилгын үнийн өсөлтөөс шалтгаалж 1 жил барилгын ажил зогссон байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж, Өөрийн байр-4, Утас1: 320444, 311251, утас2: 99116282, факс: 311251
Төслийн барилга угсралтын явц:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 40-р хороонд 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Барилгын төмөр бетон каркасны ажил 40%-тай хийгдэж байна. Нийт БУАжил нь 16%-тай явж байна

240 Хүүхдийн цэцэрлэгийн харагдах байдал	
240 хүүхдийн цэцэрлэг барих талбайн барилга барихаас өмнөх байдал	
240 хүүхдийн цэцэрлэг барих талбайн өнөөгийн байдал	
240 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих талбайн сансарын зураг	

1.3.2 DDCCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	DDCCD-BKH гэрээний дугаартай олон нийтийн хөгжлийн төв барих төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Тэш-Агь констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011454143, регистрийн дугаар 5801923.
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2023 он /2 жил/ Барилгын үнийн өсөлтөөс шалтгаалж 1 жил барилгын ажил зогссон байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол 39-48 тоот , Утас1: 88084640, 399007069
Төслийн барилга усралтын явц:	“Тэш Агь констракшн” ХХК болон “Ай Ди Си проперти” ХХК –ийн түншлэлийн гүйцэтгэж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 40-р хороо, “ОЛОН НИЙТИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” –ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь 15%-тай явагдаад байна
Олон нийтийн хөгжлийн төвийн харагдах байдал	

Олон нийтийн хөгжлийн төвийн барилга барихаас өмнөх байдал	
Олон нийтийн хөгжлийн төв барих талбайн өнөөгийн байдал	
ОНХТ барилга барих талбайн сансарын зураг	

1.3.3 SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	SHS гэрээний дугаартай Зорилтот бүлгийн 126 айлын орон сууц төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Монкон констракшн” ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9011229115, регистрийн дугаар 5372852
Төсөл хэрэгжих хугацаа:	2021-2023он /3 жил/
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	СБД, 1 хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс Оффис, 12 давхар
Төслийн барилга усралтын явц:	“Монкон Констракшн” ХХК-ийн гүйцэтгэж байгаа “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-н хүрээнд хийгдэж буй “Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо, ханын материал орчимд баригдах 9 давхар, 2 блок нийт 126 айлын түрээсийн орон сууцны барилга угсралтын ажлын гүйцэтгэл нь 80%-тай явагдаад байна
Зорилтот бүлгийн орон сууцийн харагдах байдал	
Зорилтот бүлгийн орон сууцийн барилга барихаас өмнөх байдал	

Зорилтот бүлгийн орон
сууцийн барилга барих
талбайн өнөөгийн байдал



Зорилтот бүлгийн орон
сууцны барилга барих
талбайн сансарын зураг



Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө
оруулалтыг дэмжих хөтөлбөр, 2 дугаар үе шат

Соёл амралтын хүрээлэнгийн барилга барихаас өмнөх байдал	
Соёл амралтын хүрээлэнгийн барилга барих талбайн өнөөгийн байдал	
Соёл амралтын хүрээлэнгийн сансарын зураг	

1.3.5 BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолбор төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	BDSC-BKH гэрээний дугаартай Спорт цогцолборын төсөл
Төслийн захиалагч.	Нийслэлийн Засаг даргын тамгын газар

Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	JV of Standard Holding LLC, Himon Construction LLC and Tanii Zam LLC
Төсөл хэрэгжих хугацаа:	2023 оноос барилгын ажил эхэлж 2023 ондоо дуусгах болно
Төслийн барилга усралтын явц:	Барилгын үндсэн карказын ажлыг хийж байгаа.Барилгын ажлын 25% явагдаж байна
Спорт цогцолборын харагдах байдал	
Спорт цогцолборын барилга барихаас өмнөх байдал	
Спорт цогцолборын барилга барих талбайн өнөөгийн байдал	



1.3.6 HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	HSSC-C гэрээний дугаартай салбар шугам барих төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	“Эс энд эй трейд” ХХК
Төсөл хэрэгжих хугацаа:	2023 оны 4-р сард эхэлсэн 2023 онд дуусах болно.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 8-1 тоот
Төслийн барилга усралтын явц:	Газар шорооны ажлын хүрээнд гудамж талбайн шугам тавих ажил хийгдэж дууссан. Узелийн барилгын ажил бусад холболтын ажил хийгдэнэ.Барилгын ажлын явц 40% явагдаж байна.

Салбар шугамын
холболтын ажлууд
сансарын зураг



УДДТөвийн барилга



1.3.7 FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.

Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө
оруулалтыг дэмжих хөтөлбөр, 2 дугаар үе шат


Төслийн нэр:	FSBKH гэрээний дугаартай Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	Enigma construction LLC
Төсөл хэрэгжих хугацаа:	2023-2024 онд
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	
Төслийн барилга усралтын явц:	Сонгон шалгаруулалт явагдаагүй байгаа. Барилгын ажил эхлээгүй
Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн харагдах байдал	
Гал түмэр унтраах, аврах 29-р ангийн барилга барихаас өмнөх байдал	



1.3.8 ВКНС гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл

Агуулга	Утга
Дэд төвийн нэр:	Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл.
Төслийн нэр:	ВКНС гэрээний дугаартай Баянхошуу амралтын талбай төсөл
Төслийн захиалагч:	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжүүлэгч:	“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх,хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 2 дугаар үе шат”
Төслийн туслан гүйцэтгэгч:	-
Төсөл хэрэгжих хугацаа:	-
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	-
Төслийн барилга усралтын явц:	Сонгон шалгаруулалт явагдаагүй байгаа. Барилгын ажил эхлээгүй

Баянхошуу
амралтын талбайн
сансарын зураг



2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГАА


2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төслийн талбай нь хотын баруун урд хэсэгт орших бөгөөд Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөсч тохойрсон татам болон дэнжийн хэсэгт байрладаг. Газарзүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд багтдаг бөгөөд 1950-2268 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсаар хүрээлэгдэнэ.

Газрын гадарга: Хотгор гүдгэрийн хувьд тэгшрэлийн гадарга бүхий нэгэн уулсын системийг үүсгэх боловч гадаад хүчний нөлөөгөөр өөрчлөгдөн хувирсаар хэд хэдэн ширээ өндөрлөг болон гол, горхи ам хөндийгөөр ихээхэн хэрчигджээ. Уулсын хажуу нь тэгш бус байрлалтай хойт хажуу нь богиновтор, өмнөд хажуу нь урт ерөнхийдөө уулсын баруун хагасын хажуу нь эрс байна. Уулсын гадаргад хад чулуу, асга, чулуун нуранги элбэгтэй.

Байгалийн бүслүүр: Дархан цаазат Богдхан уул нь Хэнтийн нурууны уулархаг мужийн баруун өмнөд захад орших боловч өндрийн нөлөөгөөр ой, тайгын ландшафт голлох байр эзэлдэг. Богдхан уул нь манай орны зүүн хэсэг дэхь ойн тархалтын хамгийн урд хэсэг болдог бөгөөд зүүн өмнөд ба өмнөд хэсгээрээ хуурай хээрийн ландшафттай залгадаг тул ургамал, амьтны зүйлийн тархалтын хувьд ихээхэн өвөрмөц юм. Амьтны газарзүйн мужлалын хувьд умардын их мужийн хөвч тайгын дэд муж, Хэнтийн тойрогт багтана.

Зураг 2-1. Баянхошуу нийгмийн барилга байгууламж барих талбайн физик газарзүйн байрлал



2.2 Уур амьсгал

Төслийн талбай орших Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -38.3°C хүрдэг, үнэмлэхүй их температур нь 36.9°C хүрдэг, үнэмлэхүй их бага температурын агууриг нь (75.2°C) эрс тэс ялгаатай.

Жилийн дундаж температур нь 0.4°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -21.3°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 19.5°C байдаг байна. Улаанбаатар хотод жилд дунджаар 257.1 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 173.1 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 89 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна. Салхины зонхилох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруунаас нийт салхины чиглэлийн 22.1% баруун хойноос, хойноос 20%, баруунаас 13.5% давтагдалтай байдаг. Салхины хурдны олон жилийн дундаж нь төдий л ихгүй ойролцоогоор 2.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг байна.

2.3 Агаарын чанар

Энэ хэсэгт төсөл хэрэгжих орчны агаарын чанарын төлөв байдлыг бүс нутгийн хэмжээгээр Улаанбаатар хотын хэмжээгээр агаарын бохирдлын эх үүсвэр, агаарын бохирдлын талаарх судалгааны үр дүнгээр авч үзлээ. Цаг уурын орчны шинжилгээний газрын агаарын чанарыг хянах Нисэх станцын мэдээг ашиглан тодорхойлов. Агаарын чанарыг хянах Баянхошуу дүүрэг, 7-р хороо, ШТС орчим нутагт байрлана.

2.3.1 Агаарын чанарын ерөнхий төлөв

2017-2019 онд төслийн талбай орчмын бүс нутгийн агаарын чанарын төлвийг тодорхойлох хяналтын цэгт хийсэн агаар дахь бохирдуулах бодисын жилийн дундаж агууламжийг Агаарын чанарын MNS 4585:2007 стандарт /АЧС гэх/ дахь хүлцэх хэм хэмжээ /XXX/-тэй харьцуулахад хүхэрлэг хийн агууламж 0.022 мг/м^3 -д хүрч 0.8 дахин, том ширхэглэгт тоосонцорын агууламж 0.145 мг/м^3 -д хүрч 3.1 дахин, нарийн ширхэглэгт тоосонцорын агууламж 0.084 мг/м^3 -д хүрч 2.86 дахин, азотын давхар ислийн агууламж 0.017 мг/м^3 -д хүрч 0.4 дахин тус тус их байсан байна.


2.4 Геологийн тогтоц

2004-2005 оны геоэкологийн региональ судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын дэвсгэр талбайд болон зэргэлдээх зарим дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн тогтоцын хувьд доод-дунд девон, доод-дунд карбоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг, дээд триас-доод юрийн настай гүний шургамал чулуулаг, доод цэрд, неогены плиоцены үеийн шаварлаг, түүнчилэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас зонхилон тархажээ. Иймд тухайн бүс нутгийн геологийн тогтоцын дээр дурьдсан өвөрмөц онцлогийг үндэслэн, 2004-2005 онд явуулсан геоэкологийн региональ

судалгааны талбайд тархсан нийт насны хурдас, чулуулгийг дараахи давхарга зүйн ангилалд хамааруулж байна. Үүнд:

- Доод-дунд девоны настай тунамал-бялхмал-хувирмал чулуулгийн зузаалаг (D_{1-2})
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг (C_{1-2})
- Дээд триас-доод юрын настай гүний шургамал чулуулгийн массив (T_3-J_1)
- Доод цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг (K_1)
- Неогены плиоцены үеийн шаварлаг хурдасны зузаалаг (N_2)
- Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас / Q /

Зураг 2-2. Төслийн талбай, түүний орчмын геологийн зураг



2.4.1 Геоморфологийн нөхцөл

Төслийн бүс талбай орчмын бүс нутгийн геоморфологийн нөхцлийн хувьд газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн хэв шинжийн элэгдэл, идэгдэл-элэгдэл-хуримтлал болон хуримтлалын төрлийг ялгаж болно. Өндөр уулын бүсийн усан хагалбарын мужид зөвхөн газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн элэгдлийн хэв шинж зонхилж байхад намхан хэлхээ уул, бэсрэг толгодын хажуу ташлаг, энгэр, бэл, хормой болон гуу жалга, дэнжийн мөргөцгийн хэсэгт гадаргуугийн идэгдэл-элэгдэл-хуримтлалын төрөл давамгайлдаг.

2.5 Гадаргын ус


Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн “Баянхошуу-Ханын материалын нийгмийн барилга байгууламж барих” талбайн

гадаргын усны төлөв байдлын талаар тусгалаа. Улаанбаатар хотын дэвсгэр талбай болон зэргэлдээх зарим дүүргийн бүс нутаг нь газар зүйн байршлын хувьд ойт хээрийн бүсэд 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг өндөр уулсын муж, түүнчлэн Туул голын ай сав, түүний хажуу жигүүрийн жижиг цутгал голуудын хөндийн хэмжээнд багтаж байрладаг. Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэгт тархан байрласнаас гадна Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид гол барилга, байгууламж тархжээ. Түүнчлэн Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог

2.5.1 Төслийн талбай орчмын гадаргын усны сүлжээ

Энэ бүс нутагт байгалийн тогтоц, уур амьсгалын нөхцлөөсөө хамааран гадаргын усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн. Төслийн талбайд ойролцоо орших гадаргын усан сүлжээ нь Толгойтын баруун болон зүүн салааны гол юм. Төслийн талбайгаас Толгойтын баруун болон зүүн салааны голын салаа нь 240-360 м, Туул гол 6.2 км зайтай урсдаг.

Зураг 2-3. Төслийн талбай орчмын гадаргын усан сүлжээ




2.6 Гидрогеологийн нөхцөл

Судалгаанд хамрагдсан дэвсгэр талбайн хэмжээнд тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцлийг илэрхийлж буй газрын доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын байгалийн ерөнхий зүй тогтол болон геологийн тогтоцын суурь нөхцлийн өвөрмөц онцлогийг үндэслэн, гидрогеологийн давхрага зүйчлэлийн хувьд дараах уст үе давхарга, цогцолбор, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна Үүнд:

- Голоцены үеийн аллювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (alQ_2)
- Дунд-дээд плейстоцений үеийн делюви-пролювийн гарал үүсэлтэй сэвсгэр хурдасны уст давхарга (dpQ_{1-2})
- Доод-дунд карбоны настай тунамал-хувирмал чулуулгийн зузаалаг дахь уст цогцолбор (C_{1-2}) зэрэг болно.

Зураг 2-4. Төслийн талбай, түүний орчмын гидрогеологи



2.7 Хөрсөн бүрхэвч

Хөрсний судалгаа явуулсан нутаг дэвсгэр нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсчилийн Хэнтийн мужийн Хэнтийн баруун хэсгийн 39-р тойргийн (Үндэсний атлас, 2009) нутгийг хамран байрлах бөгөөд хотжилт, гэр хорооллын нөлөөгөөр *Хот суурингийн эвдэрсэн хөрс* болон өөрчлөгдсөн байна (“Монгол орны хөрсний джитал зураглал, хөрсний шинэчилсэн ангилал” сэдэвт ажлын тайлан, 2014).

Улаанбаатар хотын Сонгинхайрхан дүүргийн 24,7,9,40–р хорооны Баянхошуу-Ханын материал орчмын газар нь талархаг гадаргыг хамарч далайн түвшнээс дээш 1340-1380 орчим метрийн өндөрт байрлана. Уулын нугын хар хүрэн хөрс, уулсын хоорондох нарийн ам хоолой, нарийвтар хөндийгөөр делювийн карбонатлаг хөвсгөр хурдас дээр тархана.

2.7.1 Газрын доройтол, хөрсний элэгдэл эвдрэл

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 6,7,24-р хорооны нутагт “Баянхошуу-Ханын материалын нийгмийн барилга байгууламж барих” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн

талбайд анх байгалийн нөхцөлдөө - *Уулын хархүрэн хөрс*, аллювийн ширэгт бараан хөрсүүд бүрдэл байдлаар тархдаг байсан боловч хотын хүн амын төвлөрөл, гэр хорооллын суурьшлын бүсийн нөлөөгөөр хашаа хоорондох гудамжуудаар машин техникийн зорчих хэсгийн шороон замууд үүссэн байгаа ба түүнийг дагаад хөрсний эвдрэл, доройтол ихтэй болсон байна.

2.8 Ургамлан нөмрөг

Сүүлийн жилүүдийн хотын хүн амын механик өсөлт, гэр хорооллын өсөн нэмэгдэж байдал нь ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж суурьшлын бүс бүхий газрууд, тэр дундаа хашаа хоорондох гудамж талбай ургамалгүй, халцгай нүцгэн болох нөхцөл улам бүр нэмэгдэж байна. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” Гэр хороолол хэт их төвлөрсөн, гудамж хоорондох зай талбай бага байхын зэрэгцээ хашаа хоорондох гудамжиндаа авто замын нөлөөгөөр хөрсний эвдрэл ихээр үүссэн, ихэнхдээ ургамалгүй халцгай нүцгэн байна. Гэр хорооллын зарим гудамжны хашааны ёроол хэсгийн нарийхан зурвас газарт алаг цоог ургамалтай байна. Дэд бүтэц барих талбайн ургамалжилтанд талхагдсан, олон салаа зам гарсан байна.

2.9 Амьтны аймаг

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 6,7,9-р хороонд хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” –ийн “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл” нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)–аар Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Хэнтийн тойрогт багтах бөгөөд Нийслэлийн хотын суурьшлын бүс нутагт оршиж байна.

2.9.1 Төслийн талбай орчмын амьтны зүйл бүрдэл


Төсөл хэрэгжих талбай, түүний орчмын бүс нутагт хүн амын хэт төвлөрөл, хотжил, хүн малын нөлөө, бэлчээрийн талхлагдал зэргийн нөлөөллөөс амьтны аймгийн амьдрах нөхцөл алдагдаж зөвхөн хот суурин газарт амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrhocorax pyrhocorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай олон үзэгдэж байлаа. Хөхтний дотроос хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас голдуу төрөл бүрийн цохын овог тааралдана. Эдгээрийн дотор Монгол Улсын Улаан ном (1987)-д орсон ховор, ховордож буй, Вашингтоны конвенци (CITES)-ийн 2-р хавсралтад хамрагдсан амьтан үгүй болно

2.10 Тусгай хамгаалалттай газар нутаг

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 6,7,9,40-р хороонд хэрэгжих “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” –ийн “Баянхошуу-Ханын материалд нийгмийн барилга байгууламж барих төсөл” нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцахгүй юм. Тус төслийн талбайгаас улсын тусгай хамгаалалттай Богдхан уулын ДЦГ урд зүгт 7.8 км, Чингэлтэй уулын БНГ-ын 2-р хэсэг баруун хойд зүгт 11.9 км, дүүргийн тусгай

хамгаалалттай Бурхантын хэмээх газар баруун хойд зүгт 12.1 км, Сонгинохайрхан уулын тусгай хамгаалалттай газар баруун урд зүгт 9.9 км зайтай оршдог.

Зураг 2-5. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд



2.11 Түүх, соёлын өв

Төслийн талбайд Эс И Си ХХК-ийн судалгааны багийн 2019 оны 9 сард хийсэн байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгаагаар түүх, соёлын өв бүхий ямар нэгэн дурсгал илрээгүй байна.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮН, НИЙТ ЗАРДАЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тайлагнах эрх үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Улаанбаатар хотын захиргаа, түүнийг төлөөлөн төслийг өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж буй Төслийн Удирдах Нэгж хүлээх бол БОМТ-д заагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллах үүргийг барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагууд хүлээнэ. БОМТ-г хэрэгжүүлэх төсөв зардлыг барилгын ажлын гэрээнд тусган оруулж өгөх бөгөөд гэрээт гүйцэтгэгч байгууллагууд нь барилгын ажлын явцад талбайн байгаль орчны ажилтан авч ажиллуулах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **106сая369мянга 800төгрөг** болох бөгөөд зардлын хураангуйг гэрээт ажлын **7 багц** тус бүрээр ангилан доорх хүснэгтэд үзүүлэв.

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Хүснэгт 3-1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Менежментийн арга хэмжээ	Гэрээт ажлын багцууд							Нийт дүн, төгрөг
		ASKG-BKH	DDCD-BKH	BDSC-BKH	FRS - BKH	DDPK-BKH	HSSC-C	BKHS	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	629 450.0	636,000	810,000.0	3,053,350	860,000	1,610,000	8,400,000	15,998,800
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	7,230,380.00	11,183,060	6,329,080.00	6,329,080.00	6,272,625.00	-	20,066,400	57,410,625
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-	-	-	-	-	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,650,000	1,650,000	1,650,000	1,650,000	1,650,000	1,650,000	1,650,000	11,550,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	995,767.8	995,767.8	995,767.8	1,630,767.8	1,630,767.8	1,630,767.8	1,630,767.8	9,510,375
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	1,300,000	1,300,000	1,300,000	1,300,000	1,500,000	2,600,000	1,500,000	11,900,000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал, төгрөг		106,369,800 төгрөг (Барилгын ажлын гэрээний үнийн дүнд багтсан)							

4 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4-1. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Хүүхдийн цэцэрлэг барих ASKG-BKH багц

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
2021 онд газар шорооны ажилд 0.24 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүссэн	Хүүхдийн цэцэрлэгт 1168 м.кв тоглоомын талбай тохижуулна.	Барилгын ажлын талбай	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан			Барилга угсралтын ажил дууссаны дараа	
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Барилгын суурь ухах, 0.24 га талбайн цэвэрлэгээ тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох Хүчтэй салхи шуургатай үед шороон материалын овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж хучиж бүтээх	Барилгын ажлын талбай	Усны хэмжээ тонн	93.15 м3	3000	279 450	Барилгын ажлын туршид
Барилга угсралтын ажлын үед цемент, шохой зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд дэгдэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Барилгын ажлын талбай	Үйл ажиллагааны зардалд багтсан			7 хоногт 1-2 удаа	
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Газар шорооны жил, барилга угсралтын ажил,	*Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт	Барилгын ажлын талбай	ОХШХ-т тусган оруулсан			Барилгын ажлын туршид	

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах зэрэг ажлуудаас дуу чимээ үүсэх	их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох *Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих						
Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж, зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	*Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах Барилгын түр кэмпэд ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх *Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх * Барилгын ажил явагдаж буй газруудад зориулалтын хогийн сав байрлуулах Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	Барилгын ажлын талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.				Барилгын ажлын туршид
4. Гадаргын ба газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Барилгын болон ахуйн зориулалтаар бага хэмжээний ус ашиглах	*Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах *Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Усан хангамжийн эх үүсвэр дээр	Үйл ажиллагааны зардалд багтсан				Барилгын ажлын туршид
Шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	Барилгын түр кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	Барилгын түр кэмп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан				7 хоног бүр

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрсний элэгдэл, доройтол үүсэх	*Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж барилгын материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах *Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний цэгэн элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх	Барилгын материал тээвэрлэх зам дагуу, барилгын талбай			Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан		Барилгын ажил дууссаны дараа
2021 онд ухсан барилгын суурь ухах ажлаар 2316 м2 талбайн өнгөн хөрс хуулагдаж, хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанарт өөрчлөлт гарч болзошгүй.	Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед гадна орчны тохижилт, нөхөн сэргээлтэд ашиглах	Барилгын ажлын талбай			Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан		Газар шорооны ажил явагдах хугацаанд
Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд			Үйл ажиллагааны зардалд багтсан		Барилгын ажлын туршид
Хог хаягдал, кэмпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсч болзошгүй.	*Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх *Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох *Барилгын түр	Барилгын түр кэмп			Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.		

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ” ТӨСӨЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	кэмпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх *Барилгын түр кэмпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлораминт цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх						
6. Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө							
Барилга угсралт, барилгын материал тээвэрлэх, газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсч ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах	*Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх *Шаардлагатай тохиодолд дуу чимээ тусгаарлах зөөврийн хана ашиглах *Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх		ОХШХ-т тусган оруулсан				Хуурай өдрүүдэд, өдөрт 4-5 удаа
Барилга угсралтын үйл ажиллагааны үед барилга дээрээс юм унаж явган зорчигчийг гэмтгэх	*Барилга угсралтын үед хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд хатуу сахиж ажиллах *Шаардлагатай тохиолдолд баригдаж буй барилгын хажуугаар явган зорчигч нэвтрэх хамгаалалтын саравч бүхий гарцууд гаргаж өгөх *Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах		Тэмдгийн тоо	1	50000	50000	
Кэмпийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй зайлуулснаас үүдэн орчны бохирдол, үнэр танар үүсгэх	Барилгын түр кэмп бүрт дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд: 1. Хатуу хог хаягдлын менежмент. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, СХД-ийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх	Барилгын түр кэмп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.				Барилгын ажлын туршид

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	2. Шингэн хог хаягдлын менежмент. Кэмпээс гарах бохир усыг битүү саванд түр хадгалж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх 3. Ажилчдын 00. Эрүүл ахуйн шаардлага хангасан 00-той байх, 00-н нүхэнд био-бэлдмэл ашиглаж халдваргүйжүүлэлт хийх, ойр орчмыг нь хлораминт шингэнээр тогтмол ариутгаж цэвэрлэх						
Кэмийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	*Барилгын ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх *Кэмийн орчинд мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох	Барилгын бүх ажилчид	Энэ төлөвлөгөөний 7-р хэсэгт заагдсан төсвийн төсвийн хүрээнд				Барилгын ажил эхлэхээс өмнө
7. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ							
Гүйцэтгэгчийн БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь БОАЖЯ-аар батлагдсан энэхүү БОМТ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө буюу Г-БОМТ-г боловсруулж ТУН-д хянуулж батлуулна.	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллагын удирдлага	Үйл ажиллагааны зардалд багтсан				Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 30 хоногийн дотор
БОМТ-г хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт, боловсон хүчинтэй байх	Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь талбайн байгаль орчны ажилтантай байх ба уг ажилтан нь Г-БОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, барилгын ажлын талбарт өдөр тутмын БО-ны хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.		Барилгын ажлын төсөвт өртөгт багтсан.				Барилгын ажлын туршид

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Байгаль орчныг хамгаалах чиглэлээр инженер, барилгын ажилчдыг чадавхижуулах	Бүх барилгын ажилчдыг хамруулсан БО-ны сургалт зохион байгуулж, БО-ны чиглэлийн хууль, журмын шаардлага, стандарт, БОМТ-д тусгагдсан бууруулах арга хэмжээг тайлбарлан таниулна.		сургалтын тоо	1	300000	300000	Барилгын ажил эхлэхээс өмнө
Нийт					629 450.0		

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Хүснэгт 4-2. 2023 онд хэрэгжүүлэх Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Олон нийтийн хөгжлийн төв барих DDCD-BKH багц

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
2021 Оны газар шорооны ажилд 0.11 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	Олон нийтийн хөгжлийн төв барих, автомашины зогсоол зэргийг байгуулна.	Барилгын ажлын талбай	Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд тусгасан				Барилга угсралтын ажил дууссаны дараа	Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.03
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
Барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлаас тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м2 талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Барилгын ажлын талбай	Усны хэмжээ тонн,	112 м3	3000 ¹⁰	336,000	Барилгын ажлын туршид	MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага
Авто машин бусад тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал ялгарна.	Төсөл хэрэгжиж буй үед агаарын шинжилгээг хийлгэж ажиллах MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ	Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд	ОХШХ-т тусган оруулсан				5, 8 саруудад	MNS5885:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
Барилга угсралтын ажлын үед цемент, шохой зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд дэгдэж орчны агаарт	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Барилгын ажлын талбай	Үйл ажиллагааны зардалд багтсан				7 хоногт 1-2 удаа	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ: “БАЯНХОШУУ-ХАНЫН МАТЕРИАЛД НИЙГМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ
БАРИХ” ТӨСӨЛ**

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
бохирдол үүсгэж болзошгүй								
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
